



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 6226 3168, Факс: (976-11) 312 315,
E-mail: info@mrt.gov.mn, http://www.mrt.gov.mn

2016.04.11 № 03/1483
танай 2016.03.23-ны № 01/802-Т


ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.НЯМДАВАА
ТАНАА

Тушаал хүргүүлэх тухай

Иргэний нисэхийн ерөнхий газрын хүний нөөцийг хөгжүүлэн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх болон Орон нутгийн алслагдсан бүс нутгийн нислэгийг сэргээн тогтворжуулах ажлыг хэрэгжүүлэх тухай танай 2016 оны 01/802 тоот албан бичгээр ирүүлсэн дагуу баталсан "Зөвшөөрөл олгох тухай" Зам, тээврийн сайдын 2016 оны 83 дугаар тушаалыг хүргүүлж байна.

Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

СТРАТЕГИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Г.Нямдаваа* Ю.ӨЛЗИЙЖАРГАЛ





МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот


Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 8.1, 9.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-д тусгагдсан хүний нөөцийг хөгжүүлэн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх болон Орон нутгийн алслагдсан бүс нутгийн нислэгийг сэргээн тогтворжуулах ажлыг хэрэгжүүлэх тухай Иргэний нисэхийн Ерөнхий газрын 2016 оны 01/802 тоотын хавсралтад заагдсан төсөл, арга хэмжээг зохих журмын дагуу хэрэгжүүлэхийг Иргэний нисэхийн ерөнхий газар /Г.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэд үүрэг болгосугай.

САЙД



М.ЗОРИГТ

